

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Захиргааны ерөнхий хуулийг баталсан. Энэ хууль 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ.

Захиргааны ерөнхий хуулиар гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний үйл ажиллагааны олон салбарын нийтлэг асуудлыг байгууллага болгон өөрийн үзэмжээр журамлан шийдэж байгааг цэгцэлж нэгдмэл байдлаар захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан суурь хууль юм. Өөрөөр хэлбэл хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд **"ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА"** болон **"ИРГЭН", "ХУУЛИЙН ЭТГЭЭД"**-ийн хооронд үүсэх харилцааг зохицуулдаг.

ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛ ГЭДЭГ НЬ: Засгийн газраас Улсын Их Хурлын хяналт, улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хуулийн үндсэн дээр, түүний биелэлтийг захирамжлан зохион байгуулах замаар улс орны амьдралыг эрхэлж удирдах үйл ажиллагааг төрийн ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛ гэж болно. Энэхүү гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх байгууллагыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага гэж ойлгодог.

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ГЭДЭГ НЬ: Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн иргэдийн эрхийг хөндсөн захирамжилсан шийдвэр гаргадаг гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллагыг ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА гэж ойлгоно. Жишээ нь: Засгийн газар, яам, агентлагаас авахуулаад аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын алба, Тамгын газар, улсын сургууль, эмнэлэг, цагдаа, Иргэдийн төлөөлөгчдийн хурал г.м

Захиргааны байгууллага нь:

- Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага

Жишээ нь: Засгийн газар, яам, агентлаг, Засаг дарга нар;

- Хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад

Жишээ нь: Төрийн албаны зөвлөл, Монгол банк, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Татварын маргаан таслах зөвлөл зэрэг байгууллага;

- Захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан байгууллага

Жишээ нь: Монголын Улаан загалмай нийгэмлэг, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо зэрэг байгууллага

- **Үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг** төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагад **аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг болон хорооны иргэдийн Нийтийн хурал хамаарна.**
- Байнгын бус, нэг удаагийн шинжтэй асуудлыг шийдвэрлэж зохицуулах захиргааны байгууллага

Жишээ нь: Сонгуулийн үед байгуулагдах хэсэг, тойргийн хороо, тендер шалгаруулалтын үед байгуулагдах үнэлгээний хороо зэрэг байнгын бус үйл ажиллагаатай захиргааны байгууллага хамаарна.